БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА: .....Б.ДАВААНЯМ

2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

“НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН БИЕ ДААСАН НЭГДСЭН САНГ БИЙ БОЛГОХ” СИСТЕМИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

ХЯНАСАН:

ТЕХНОЛОГИ, СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА.....Б.Чойжилсүрэн...../Б.ЧОЙЖИЛСҮРЭН/

БОЛОВСРУУЛСАН:

ТЕХНОЛОГИ, СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ДАТА АНАЛИЗ ХАРИУЦСАН АЖИЛТ.....Б.Эрдэнэцэцэг...../Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ/

Улаанбаатар
2023

А.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Захиалагч: Нийслэлийн Өмчийн харилцааны газар.

Төслийн нэр: Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан нэгдсэн санг бий болгох ажил.

Төслийн зорилго: Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой нийслэлийн өмчийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн өмч хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг төвлөрүүлж, тэдгээрийг оновчтой түргэн шуурхай нэгтгэн боловсруулж, бүртгэлийг сайжруулах, тайланг солилцох, шаардлагатай мэдээллээр хангах, хяналт тавих, олон шатны хэрэглэгчид нэгэн зэрэг ашиглах боломж бүрдүүлэх зорилготой.

Төслийн хамрах хүрээ

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хамаарна. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал,
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба,
- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд,
- Нийслэлийн Өмчит төсөвт байгууллагууд,
- Нийслэлийн Өмчит аж ахуйн тооцоот байгууллагууд,
- Дүүргийн байгууллагууд,
- Нийслэлийн бусад байгууллагууд.
- Нийслэлийн өмчийн оролцоотой байгууллагууд.

Б. ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

№	Системийн бүтэц	Хамаарах мэдээллүүд
1	Хуулийн этгээдийн мэдээлэл	- Байгууллагын ерөнхий мэдээлэл - Нэмэлт мэдээлэл: • Хувьцааны мэдээлэл, • ТУЗ-ын мэдээлэл, • Богино, дунд, урт хугацааны стратеги төлөвлөлт
2	Өмчийн бүртгэл (Хуулийн этгээд)	- Газар - Барилга, байгууламж - Нийтийн эзэмшил - Тээврийн хэрэгсэл - Машин, тоног төхөөрөмж - Тавилга, эд хогшил - Бусад
3	Хөрөнгийн хөдөлгөөн	- Хөрөнгө худалдан авах - Хөрөнгө бүртгэх - Хөрөнгө данснаас хасах - Хөрөнгө шилжүүлэх - Хөрөнгө дахин үнэлэх - Их засварт оруулах - Бусад
4	Тайлан мэдээ	- Статистик маягт /15 төрөл/ - Судалгааны маягтууд - Төрөл бүрийн нэгтгэлүүд - Бусад
5	Архивын систем	- Он дараалаар архив үүсгэх /Жил бүрийн төгсгөлд бүх мэдээллийг дахин засварлах боломжгүйгээр хааж, архивлаад шинэ оны мэдээллээ оруулж эхэлдэг болгох/ - Архивласан мэдээллээс уян хатан хайлт хийх боломжтой байх
6	Санхүүгийн тайлан	- E-balance системээс санхүүгийн 6 тайланг шууд татдаг байх - Санхүүгийн тайланд шинжилгээ хийдэг байх - Санхүүгийн тайлангийн нэгтгэл хийдэг байх
7	Түрээсийн систем	- Түрээслүүлж байгаа хөрөнгийн систем - ... гэх мэт
8	Дуудлага худалдааны систем	- Тээврийн хэрэгслийн - Үл хөдлөх хөрөнгийн - ... гэх мэт

9	Актлагдсан барааны дэлгүүрийн систем	- Худалдан авагчийн модуль - Удирдлагын модуль - Хоёрдогч түүхий эдээр шууд худалдах гэх мэт
10	Системийн дотоод хяналт	– Алдаа шалгах модуль – Тайлан мэдээг санхүүгийн тайлантай тулгах модуль – Мэдээлэл үнэн зөв эсэхийг нэгдсэн цонхоор хэрэглэгчид өгөх гэх мэт
11	Хэрэглэгчийн тохиргоо	– Хандах эрхийн түвшин тогтоох – Хуулийн этгээдийн онцлогт тохирсон тохиргоо – Бусад
12	Хөрөнгө оруулалтын систем	– Их засварын арчилгаанууд – Бусад
13	Тусламж	– Системийн гарын авлага /видео хичээл/ – Холбогдох эрхзүйн баримт бичгүүдийг байршуулах

В.СИСТЕМИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

№	Шаардлагын нэр	Шаардлагууд
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага тус бүрд өөрийн байгууллагын хэмжээнд эрхийн тохиргоогоор нэвтрэх эрхийн түвшин	- Эрхийн түвшний тоо хязгааргүй байх - SSO нь UBERP нэвтрэх эрхийн түвшнийг ашиглаж, хэрэглэгч бүр өгөгдөл засах, харах, оруулах, хянах дүүрэг, хороо зэрэг нь хязгаарлагдмал байх - Эрхийн тохиргооны уян хатан нөхцөлтэй байх
2	Админ эрхийн түвшинтэй	- Нэвтрэх эрхийн хязгааргүйгээр системд нэвтрэн өгөгдөл засах, харах, оруулах, хянах зэргийг хийдэг байх
3	Хайлтын системтэй байх	- Төрөл бүрийн дугаар, он сар, байрлал, төлөв байдал гэх мэт өгөгдлүүдийг хайх уян хатан хайлтын системээр хангах - Уян хатан хайлт хийх боломжтой байх (утгын хязгаар, огноо, текст, төлөв гэх мэт)
4	Тайлан	- Хөрөнгийн ангиллаар мэдээллийг бүх түвшинд дурын цаг хугацаагаар гаргадаг байх - Бүх төрлийн болон захиалагчийн өгсөн батлагдсан тайлангийн маягтаар тайлан мэдээ, тоон үзүүлэлт, график гаргах ба doc, xlsx, pdf, jpeg өргөтгөлөөр

		хадгалах, хэвлэх, архивлах боломжтой байх. - Тайлан, мэдээг хэрэглэгчийн тусгайлсан шаардлагын дагуу зохиох, өөрчлөх боломжтой байх - Системийн ажлын урсгалын аль ч хэсгээс мэдээ хэвлэх боломжтой байх

Г. СИСТЕМҮҮДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, НЭВТРҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Гүйцэтгэгчид тавигдах тусгай шаардлага:

1.1 Систем хөгжүүлэх компани өмнө нь систем нэвтрүүлж байсан туршлагатай байх

1.2 Систем хоорондын интеграци хөгжүүлэлт хийж байсан туршлагатай байх

1.3 Өөрийн эх үүсвэрийн санхүүжилтийн чадамжтай байх

1.4 Системийн архитектур зураг гаргаж өгөх

2.Системийн программ хангамжид тавигдах стандартын шаардлага:

2.1 Системийн удирдлагын хэсэг вэб-д суурилсан байх

2.2 Нэвтрүүлэлтийн явцад системийг тестэлж, шаардлагатай шинэчлэлт, нэмэлт хөгжүүлэлтийг хийх боломжтой байх

2.3 Системийн үйл ажиллагааг бүрэн хүлээлгэж өгөхөд захиалагчийн талаас өгсөн техникийн шаардлагыг бүрэн хангасан байна.

2.4 Системийн супер admin эрхийг захиалагч талд хүлээлгэн өгөх.

2.5 Нэмэлт хөгжүүлэлт болон засвар үйлчилгээг 1 жилийн хугацаанд сервис үзүүлэх

2.6 Сервер, тоног төхөөрөмжийн ачааллыг хянадаг байх, ачаалал гарсан үед мэдэгдэл ирдэг байх

2.7 Системийн архитектур зураг гаргаж өгөх

2.8 Кибер халдлагаас (Hacking) хамгаалагдсан байх. Үүнд: - Brute force; - URL injection; - SQL injection; - Cross Site scripting; - Buffer overflow гэх мэт

2.9 Сервер компьютер асах үед систем өөрийгөө ачаалдаг байх.

2.10 Mobile responsible байдлаар ажилладаг байх

2.11 Системийн эх код, албан ёсны зохиогчийн эрхийг 100% захиалагчийн нэр дээр бүртгүүлэн хүлээлгэж өгөх

2.12 Систем хөгжүүлэлт, сайжруулалт хийсэн тохиолдол бүрд эх кодыг шинэчилсэн сүүлийн хувилбараар санах ой бүхий төхөөрөмжид хуулбарлаж захиалагчид хүлээлгэн өгнө.

2.13 Бусад системүүдтэй нийтлэг интерфейс (тухайлбал XML) ашиглан өгөгдөл солилцдог байх

2.14 Төрийн бусад системүүдтэй холбогддог байх (E-balance, E-Mongolia, Улсын бүртгэлийн газрын систем, авто тээврийн үндэсний төвийн систем, хот байгуулалтын мэдээллийн менежментийн нэгдсэн систем гэх мэт)

2.15 Өгөгдөл импорт хийх боломжтой байх

2.16 Сүлжээнд холбогдон ажиллах боломжтой байх

2.17 Төрөл бүрийн форматтай (баримт, зураг, аудио, видео, шторк гэх мэт) мэдээллийг хадгалах боломжтой байх

2.18 EDI (цахим өгөгдлийн солилцоогоор хангах)

2.19 Хайлтын системтэй байх

2.20 Task-ийг зогсоох болон дахин эхлүүлэх боломжтой байх

2.21 GOOGLE MAPS-аар үл хөдлөх хөрөнгийн байршил холбох боломжтой байх.

3. Ерөнхий шаардлага:

3.1 Монгол хэл дээр ашиглагддаг байх

3.2 Тогтвортой, найдвартай үйл ажиллагаатай байх

3.3 Хэрэглэгчийн интерфейс нь программ хангамжид баримталдаг нийтлэг стандартын дагуу хийгдсэн байх

3.4 Онлайн тусламжийн системтэй байх

3.5 Цонх, хүснэгт, талбаруудыг хэвлэх боломжтой байх

3.6 Төрийн болон орон нутгийн өмчид хэрэглэгдэж байгаа маягтууд гардаг байх

3.7 Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх

3.8 Ерөнхий мэдээлэл харах боломжтой гар утасны аппликешнтэй байх

4.Аюулгүй байдал:

4.1 Өгөгдөл засах, харах, оруулах, хянах зэрэг хандалтын түвшний хязгаарлагдмал эрхүүдээр хангадаг байх

4.2 Хэрэглэгч бүр тухайн хэрэглэгчид зөвшөөрөгдсөн эрхийн дагуу системд нэвтрэх боломжтой байх

4.3 Нууц үгийг стандартын дагуу уян хатан хянадаг байх

4.4 Internet firewall-аар системийн серверүүдийг хамгаалах

4.5 Virus-ний эсрэг аюулгүй байдал хангах

4.6 Аюулгүй байдлын өөрчлөлтүүдийн хугацааг хадгалдаг байх

4.7 Аюулгүй байдлын занал хийлэлийн эсрэг тухайн эх кодуудыг хянах тайлангуудаар хангах

4.8 Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэх

5.Төсөлд тавигдах программчлалын шаардлага:

5.1 Нийслэлийн өмчийн нэгдсэн мэдээллийн санг дэвшилтэт технологи ашиглан илүү оновчтойгоор хөгжүүлэх, боловсронгуй болгох, олон түвшний хэрэглэгчид мэдээллийн санд хандах, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх

5.2 Мэдээллийн сангийн программ хангамжийн бүх бүрдэл хэсэг нь нэг ижил дизайны шийдэлтэй, хэрэглэхэд энгийн ойлгомжтой хэрэглэгчийн интерфейс, дизайнтай байна.

5.3 Бүх төрлийн веб хөтчид нийцтэй байх (Chrome, internet explorer, Safari, Firefox гэх мэт)

6.Төсөлд тавигдах онцгой нөхцөл:

6.1 Мэдээллийн санг хэсэгчилж, бүрэн хэмжээнд нөөц хувь үүсгэх боломжтой байна.

6.2 Мэдээллийн сангийн бүх түвшний хэрэглэгчийн хийсэн үйлдлийг бүртгэдэг лог системтэй байна.

6.3 Мэдээллийн сан нь ямар нэгэн халдлагаас бүрэн хамгаалагдан программчлагдсан байна.

6.4 Серверт ашиглагдаж байгаа үйлдлийн систем, программчлалын хэл, хэрэгсэл, өгөгдлийн сан, удирдах системийн мэдээлэл, эх код зэрэг мэдээллийг НӨХГ-т хүлээлгэн өгөх ба мэдээллийн сангийн программын тайлбар, гарын авлага, сургалтаар бүрэн хангана.

6.5 Инженерчлэл ба засварын үйлчилгээ: 2 жил

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

---oOo---